



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2022 оны 12 сарын 05 өдөр

Дугаар 84

Мандалговь

Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах,
хөрөнгөд үнэлгээ тогтоож, худалдах
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.1, 77.3 дахь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 09 дүгээр тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ийн 1 дүгээр зүйлийн 1.3 дахь заалт, 6 дугаар зүйлийн 6.4.1, 6.4.3 дахь заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит арванхоёрдугаар хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Сайхан-Овоо сумын Засаг даргын Тамгын газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй нийт 5,800,000 /таван сая найман зуун мянга/ төгрөгийн балансын үнэтэй 37,500 /гучин долоон мянга таван зуун/ төгрөгийн үлдэгдэл өртөгтэй НҮУНДАI Портер болон бага оврын тракторыг нэгдүгээр хавсралтаар акталж, данснаас хасах, нийт 10,390,828 /арван сая гурван зуун ерэн мянга найман зуун хорин найман/ төгрөгийн балансын үнэтэй, 3,501,137 /гурван сая таван зуун нэг мянга нэг зуун гучин долоон/ төгрөгийн үлдэгдэл өртөгтэй 3 ширхэг барилгын худалдах доод үнийг хоёрдугаар хавсралтад заасны дагуу тогтоон нээлттэй дуудлагын худалдаагаар худалдахыг зөвшөөрсүгэй.

2. Орон нутгийн өмчийн газар (Б.Адъяасүрэн), Сайхан-Овоо сумын Засаг даргын Тамгын газар (С.Болоржаргал) нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай.

2.1 Эд хөрөнгийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу худалдаж, хөрөнгө худалдсанаас орох орлогыг орон нутгийн хөрөнгө борлуулсны орлогын 100080000962 тоот дансанд бүрэн төвлөрүүлэх;

2.2 Актлах хөрөнгийг сум, байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналт дор акталж, акталснаас гарсан сэлбэг, материалыг эргэлтийн хөрөнгөд бүртгэх, худалдан борлуулж, орлогыг орон нутгийн хөрөнгө худалдсаны орлогын дансанд төвлөрүүлэх, хаягдал төмрийг “Дарханы төмөрлөгийн үйлдвэр” ТӨХК-д тушаах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.3 Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.4 Энэ тогтоолын биелэлтийг 2023 оны 1 дүгээр улиралд багтаан Орон нутгийн өмчийн газарт ирүүлэх.

3. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга (Ц.Мөнхбат)-д үүрэг болгосугай.

ДАРГА  С.ОД-ЭРДЭНЭ




Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2022 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн
87 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралт

Сайхан-Овоо сумын Засаг даргын Тамгын газрын актлах тээврийн хэрэгслийн мэдээлэл

№	Тээврийн хэрэгслийн төрөл	Марк	Улсын бүртгэлийн		Үйлдвэрлэсэн он	Ашиглалтад орсон огноо	Тээврийн хэрэгслийн			Нийт гүйлт /км/	Балансын үнэ	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэгдэл өртөг
			Се ри	Дуг аар			Арлын дугаар	Моторын дугаар	Моторын эзлэхүүн /см3/				
1	HYUNDAI Портер ачааны автомашин	Портер 150	-	-	1999	2012	224861	631279	1800	290664	5,500,000	5,500,000	-
2	Бага оврын трактор		-	-	2010	2010	-	-	-	-	300,000	262,500	37,500
Хөрөнгийн нийт дүн											5,800,000 /таван сая найман зуун мянга/ төгрөг	5,762,500 /таван сая долоон зуун жаран хоёр мянга таван зуу/ төгрөг	37,500 /гучин долоон мянга таван зуу/ төгрөг

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2022 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн
өдрийн 87 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралт



Сайхан-Овоо сумын Засаг даргын Тамгын газрын худалдах барилгын мэдээлэл

д/д	Хөрөнгийн нэр	Зориулалт	Хүчин чадал		Ашиглагдсан орсон он	Ашиглалтын нийт хугацаа /жилээр/	Балансын үнэ	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэгдэл өртөг	Худалдах доод үнэ
			хэмжих нэгж	Биет хэмжээ						
1	3-р багийн контор /Найз/	барилга	м2	88	1968	53	1,500,000	248,858	1,251,142	500,000 /таван зуун мянга/ төгрөг
2	4-р багийн контор /Төгрөг/	Барилга	м2	120	1972	49	7,800,000	6,305,000	1,495,000	1000,000 /нэг сая/ төгрөг
3	Орон сууц	Орон сууц	м2	64	1988	33	1,090,828	335,833	754,995	2000,000 /хоёр сая/ төгрөг
Дүн							10,390,828 /арван сая гурван зуун ерэн мянга найман зуун хорин найман/ төгрөг		3,501,137 /гурван сая таван зуун нэг мянга нэг зуун гучин долоон/ төгрөг	